

LEGAL NEWSLETTER

2024 он 01-р сар №41

Нэг. Батлагдсан хууль, хуулийн нэмэлт, өөрчлөлт

1.1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, тогтмол судалгаа шинжилгээ хийх зорилготой “**Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль**” 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр батлагдлаа.

Уг хуулиар хүн амын эрүүл мэндийг тандан судалж, эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээ авахаар зохицуулагдсан байна.

1.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон “Өрийн удирдлагын тухай хууль”-д тус тус нэмэлт, өөрчлөлт орж Нийслэлийн зүгээс Засгийн газрын баталгаатай үнэт цаас гаргах мөн Нийслэл бие даан худалдан авалт хийх боломжтой болсон байна.

Хоёр. Хүчин төгөлдөр болсон хууль, хуулийн нэмэлт, өөрчлөлт

2.1. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан багагүй хуульд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнээс онцлох нэмэлт, өөрчлөлтийг танилцуулбал:

Автотээврийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Нийслэлд тээврийн хэрэгслийн бүртгэлийн тоо хэмжээ хязгаартай болж, уг хязгаарлалтад багтаан улсын дугаар авах тээврийн хэрэгслийн төрөл, ангилал, шалгуур үзүүлэлтийг Засаг дарга батална.
- Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг худалдах, бэлэглэх, барьцаалах замаар бусдад шилжүүлж болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Тээврийн хэрэгслийн торгуулийг заасан хугацаанд төлөөгүй, үзлэгт хамрагдаагүй, зам ашигласны болон агаарын бохирдлын төлбөр зэргийг төлөөгүй тохиолдолд зөрчлийг арилгаж дуустал тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлана.

Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Нийслэл хотын дүрмээр зохицуулах 21 төрлийн харилцааг тодорхойлсон бөгөөд үүнд, Нийтийн тээврээр үйлчлүүлэх, Дрон ашиглах гэх мэт сонирхолтой харилцаа багтсан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үнийг тодорхойлох арга, дэс дараалал өөрчлөгдсөн.

Тухайлбал, Газрын эрхийг анх удаа эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ суурь үнэ байхгүй тохиолдолд “**өмчлөгчийн мэдүүлсэн зах зээлийн үнэ**”-р бүртгэдэг байсан бол нэмэлт, өөрчлөлт орсноор “**дуудлага худалдааны үнэ**”-р бүртгэдэг болсон байна.

Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Төрийн албан хаагч хуульд заасны дагуу 7 хоног бүр ажлын нэг өдөр гэрээсээ ажиллахаар болсон ч “зайлшгүй тохиолдолд” албан хаагчийг дуудан ажлын байранд нь ажиллуулах эрх хэмжээ удирдлагад мөн олгогдсон байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Хотын байгуулалтын тухай хуульд заасан шаардлага хангаагүй үл хөдлөхөөс нэмж 1 хувийн татвар авна.

 Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах ажилд хэрэглэх барилгын материал, машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлнө.

 Газрын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор сервитут тогтоох асуудлыг зохицуулсан.
- Газрын маргааныг урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагааг шинээр зохицуулж өгсөн байна.

2.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж

- “Эрүүл мэндийг дэмжих сан”-гийн зориулалт, зарцуулалтын цар хүрээг өргөжүүлсэн байна.

2.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж

- Эмэгтэй цэргийн албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа зөвхөн 2 удаа дахин хүүхэд төрүүлсэн тохиолдолд тэтгэмж олгодог байсан хязгаарлалт байхгүй болсон байна.

2.4. Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр

- Мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах гэмт хэргийг үйлдсэн эрх бүхий албан тушаалтанд
- мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдэд хорих ял ногдуулах боломжтой болсон байна.

**** Уг Хууль, эрх зүйн мэдээлэл нь албан ёсны хууль зүйн зөвлөгөөнд хамаарахгүй бөгөөд зөвхөн нийтийн мэдээлэл хүргүүлэх зорилготой болно*

Бэлтгэсэн:

Хуульч

Ч.Билгүүн

Email: bilguun@akp.mn

Tel. 99196678